



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 411

Улаанбаатар хот

Стандарт батлах тухай

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь хэсэг; Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2016 оны 12 дугаар сарын 01 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Биологийн хөрөнгө ба түүнээс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн стандарт”-ыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Хоёр. Тус стандартыг аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авахыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Энэ тушаалын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар / Б.Доржсэмбэд/-т үүрэг болгосугай.



Б.ЧОЙЖИЛСҮРЭН

Сангийн сайдын 2016 оны 411 тоот тушаалын

1 дүгээр хавсралт



**БИОЛОГИЙН ХӨРӨНГӨ БА ТҮҮНЭЭС ХҮЛЭЭН АВСАН
ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН СТАНДАРТ**

**БИОЛОГИЙН ХӨРӨНГӨ БА ТҮҮНЭЭС ХҮЛЭЭН АВСАН
ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН СТАНДАРТ**

АГУУЛГА

НЭГ. ЗОРИЛГО

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

ГУРАВ. НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

ДӨРӨВ. БИОЛОГИЙН ХӨРӨНГӨ БА ТҮҮНЭЭС ХҮЛЭЭН АВСАН
ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ

ТАВ. БИОЛОГИЙН ХӨРӨНГӨ БА ТҮҮНЭЭС ХҮЛЭЭН АВСАН ХӨДӨӨ АЖ АХУЙН
БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ БОДИТ ҮНЭ ЦЭНИЙН ЗАГВАРААР ХЭМЖИХ НЬ

ЗУРГАА. БИОЛОГИЙН ХӨРӨНГӨ БА ТҮҮНЭЭС ХҮЛЭЭН АВСАН ХӨДӨӨ АЖ
АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ӨРТГИЙН ЗАГВАРААР ХЭМЖИХ НЬ

ДОЛОО. ХӨДӨӨ АЖ АХУЙН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ОНЦЛОГ АСУУДАЛ

НАЙМ. ТАЙЛБАР, ЖИШЭЭ

ЕС. ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ 1 – Хөдөө аж ахуйн компаниудад мөрдөх дансны үлгэрчилсэн жагсаалт

ХАВСРАЛТ 2 – Хөдөө аж ахуйн компаниудын тайлангийн маягт ба тодруулга

НЭГ. ЗОРИЛГО

- 1.1. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгж биологийн хөрөнгө ба түүнээс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлтэй холбоотой зардлыг бүртгэж, тайлагнахад энэ стандартын зорилго оршино.
- 1.2. Хэрэв энэ стандартын аль нэг заалт нь НББОУСХ-оос гаргасан СТОУС-тай зөрчилдвөл СТОУС-ыг мөрдөнө.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1. Уг стандартыг фермерийн мал аж ахуй болон газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн дараах зүйлсийн хувьд уг стандартыг ашиглана. Үүнд:
 - 2.1.1. Эх ургамлаас бусад биологийн хөрөнгө;
 - 2.1.2. Хүлээн авалтын үеийн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн; ба
 - 2.1.3. Хөдөө аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой засгийн газрын буцалтгүй тусламж.
- 2.2. Бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагын хувьд уг стандартыг жишиг баримт бичиг болгон ашиглаж болно.
- 2.3. Хөдөө аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой дараах хөрөнгийг энэ стандартын хамрах хүрээнд авч үзэхгүй. Үүнд:
 - 2.2.1. Эх ургамлыг түүнд хамаарах хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээс тусад нь буюу НББОУС 16 “*Үндсэн Хөрөнгө*”-ийн дагуу;
 - 2.2.2. Эх ургамалтай холбоотой засгийн газрын буцалтгүй тусламжийг НББОУС 20 “*Засгийн Газрын Буцалтгүй Тусламж ба Тусалцааны Тодруулга*”-ын дагуу;
 - 2.2.3. Хүлээн авалтын дараах хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг НББОУС 2 “*Бараа Материал*”-ын дагуу;
 - 2.2.4. Биологийн хөрөнгө өсч эсвэл ургаж, сайжирч эсвэл хөгшрөх үйл явц явагддаг газрыг НББОУС 16 “*Үндсэн Хөрөнгө*”, НББОУС 40 “*Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө*”-ийн аль тохирохыг;
 - 2.2.5. Хөдөө аж ахуйн үйл ажиллагаанд хамаарах тусгай зөвшөөрөл, зохиогчийн эрх гэх мэт биет бус хөрөнгийг НББОУС 38 “*Биет Бус Хөрөнгө*”-ийн дагуу;
 - 2.2.6. Хөдөө аж ахуйн үйл ажиллагаа явуулах зорилгоор түрээсэлсэн газарт хамаарах хөрөнгө ашиглах эрхийг СТОУС 16 “*Түрээс*”-ийн дагуу.

ГУРАВ. НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

- 3.1. Энэхүү стандартад хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
 - 3.1.1. *Биологийн хувьсал (biological transformation)* гэж биологийн хөрөнгөд тооны ба чанарын өөрчлөлт гарахад нөлөөлдөг өсөлт, хөгшрөлт, үйлдвэрлэл болон нөхөн үржлийн үйл явц буюу түүнд гарч буй жам ёсны өөрчлөлт. Үүнд амьд амьтан, ургамлын өсөлт, насжилт эсвэл өвчлөлийн улмаас түүний гарц буурах, мөн нөхөн үржлийг нь удирдах замаар биологийн шинэ хөрөнгө бүтээх зэрэг орно.
 - 3.1.2. *Биологийн хөрөнгө (biological asset)* гэж бүх амьд амьтан ба ургамал.
 - 3.1.3. *Биологийн бүтээгдэхүүний бүлэг (a group of biological assets)* гэж ижил төстэй ургамал эсвэл амьтны нэгдэл.
 - 3.1.4. *Бодит үнэ цэн (fair value)* гэж ажил гүйлгээг хэмжих өдөр зах зээлд оролцогчдын хооронд хийгдэх зохих ёсны арилжаагаар хөрөнгийг худалдах буюу өр төлбөрөөр тооцох үнэ.
 - 3.1.5. *Борлуулалтын зардал (costs to sell)* гэж хөрөнгийг данснаас хасахтай шууд хамаарал бүхий өсөн нэмэгдүүлсэн зардал бөгөөд үүнд санхүүгийн зардал, орлогын татварын зардлыг оруулахгүй. Борлуулах цэг дээр гарах зардалд брокер, диллерийн шимтгэл, биржийн арилжааны хураамж, хөрөнгө шилжүүлсэний татвар багтдаг. Харин тухайн хөрөнгийг зах зээлд хүргэхэд зайлшгүй гарах тээврийн болон бусад зардал (орлогын албан татвар, санхүүгийн зардал) нь бодит үнэ цэнийн тооцоололд шингэсэн байдаг тул эдгээр зардлыг оруулахгүй.

- 3.1.6. *Бүтээгдэхүүн хүлээн авалт (harvest)* гэж биологийн хөрөнгөөс хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн хүлээн авах, хураах буюу салгах, эсвэл биологийн хөрөнгийн амьдралын мөчлөгийг зогсоох үйл явц юм. Биологийн хувирал эсвэл бүтээгдэхүүн хүлээн авалтын улмаас үүсэх чанар (генетик шинж чанар, болц, өөхөн бүрхүүл, уургийн агууламж, бат бөх байдал гэх мэт)-ын ба тоо (үр удам, жин, эзлэхүүн, урт, диаметр, дэлбээний тоо гэх мэт)-ны өөрчлөлтийн хүрээнд бодит үнэ цэнийн өөрчлөлтийг хэмжинэ.
- 3.1.7. *Таваарын биологийн хөрөнгө (consumable biological assets)* гэж хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн хэлбэрээр хүлээж авах эсвэл биологийн хөрөнгө байдлаар худалдах хөрөнгийг хэлнэ. Жишээ нь махны чиглэлийн мал сүрэг, борлуулах зорилгоор эзэмшиж байгаа мал амьтан, эрдэнэ шиш, буудай гэх мэт үр тариа, модон материал болгох зорилгоор ургуулсан суулгац.
- 3.1.8. *Үржлийн биологийн хөрөнгө (bearer biological assets)* гэж үр жимсээ өгдөг боловч өөрөө хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн болдоггүй, нөхөн үйлдвэрлэгч хөрөнгө юм.
- 3.1.9. *Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн (agricultural produce)* гэж биологийн хөрөнгөөс хүлээн авсан бүтээгдэхүүн.
- 3.1.10. *Хөдөө аж ахуйн үйл ажиллагаа (agricultural activity)* гэж аж ахуйн нэгж биологийн шинэ хөрөнгийг борлуулах эсвэл шилжүүлэх, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн эсвэл биологийн шинэ хөрөнгө үйлдвэрлэх зорилгоор биологийн хувирал ба биологийн хөрөнгийн хүлээн авалтыг удирдаж явуулах үйл ажиллагаа.
- 3.1.11. *Эх ургамал (bearer plants)* гэж дараах 3 шалгуур үзүүлэлтийг бүгдийг нь хангаж байгаа амьд эх ургамлыг хэлнэ. Үүнд:
- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх буюу бэлтгэн нийлүүлэхэд ашиглаж байгаа;
 - Нэгээс дээш тайлант хугацаанд үр жимс хураан авахаар хүлээгдэж буй;
 - Үлдэгдэл хэсгийг нь тохиолдлоор борлуулахаас бусад тохиолдолд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн хэлбэрээр ирээдүйд борлуулахаар таамаглаж буй.

ДӨРӨВ. БИОЛОГИЙН ХӨРӨНГӨ БА ТҮҮНЭЭС ХҮЛЭЭН АВСАН ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ

4.1. БИОЛОГИЙН ХӨРӨНГӨ БА ТҮҮНЭЭС ХҮЛЭЭН АВСАН ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ШАЛГУУР

Биологийн хөрөнгө, түүнээс хүлээж авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг зөвхөн дараах гурван шалгуурыг нэгэн зэрэг хангасан тохиолдолд санхүүгийн тайланд хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө:

- Хяналт:* өнгөрсөн үйл явдлын үр дүнд аж ахуйн нэгж уг хөрөнгийг хянадаг;
- Дүн:* уг хөрөнгөтэй холбоотой ирээдүйн эдийн засгийн өгөөжийг тухайн аж ахуйн нэгж хүртэх магадлалтай;
- Хэмжилт:* уг хөрөнгийн бодит үнэ цэн эсвэл өртгийг найдвартай хэмжиж болохуйц байвал.

4.2. АНХНЫ БА ДАРАА ҮЕИЙН ХЭМЖИЛТ

Биологийн хөрөнгө, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг анх удаа болон дараагийн тайлант үеүдэд бодит үнэ цэнийн загвар эсвэл өртгийн загварын дагуу хэмжиж бүртгэх бөгөөд тухайн горимыг дараагийн тайлант хугацаанд тууштай мөрдөнө.

4.3. БИОЛОГИЙН ХӨРӨНГИЙН ТОЛИЛУУЛГА

Биологийн хөрөнгийг эргэлтийн буюу таваарын биологийн хөрөнгө, эргэлтийн бус буюу үржлийн биологийн хөрөнгө гэж ангилан санхүүгийн байдлын тайланд толилуулах бөгөөд ингэж ангилахдаа дараах шинж чанарыг харгалзана. Үүнд:

4.3.1. *Эргэлтийн буюу таваарын биологийн хөрөнгө* гэж дараах шинж чанар бүхий мал амьтан, ургамал:

- а) Үр суулгаснаас хойшхи эхний эсвэл хоёр дахь жилээс нь хураан авалт хийдэг ургамал;
- б) Нялх төл, махны чиглэлийн мал сүрэг, үслэг эдлэлд ашиглахаар тэжээж буй амьтад.

4.3.2. *Эргэлтийн бус буюу үржлийн биологийн хөрөнгө* гэж морь, үхэр, тэмээ, хонь, ямаа болон гахай, галуу зэрэг үндсэн сүргийн тэжээвэр амьтан, мөн аж ахуйн өөр чиглэлээр тэжээж байгаа амьтад.

4.4. ДАРАА ҮЕИЙН ЗАРДАЛ

4.4.1 Хөдөө аж ахуйн үйл ажиллагаанд хамаарах дараа үеийн зардлыг үйлдвэрлэлийн ба үйл ажиллагааны зардал гэж 2 ангилна.

4.4.2 *Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зардал*

- а) Үйлдвэрлэлийн зардал нь шууд материал, шууд хөдөлмөр, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлаас бүрдэнэ. Нийтлэг гардаг дараах төрлийн үйлдвэрлэлийн зардлыг мал аж ахуй болон газар тариалангийн салбарын хувьд ангилан харуулбал:

Үйлдвэрлэлийн зардлын ангилал	Мал аж ахуй, фермерийн салбар	Газар тариалангийн салбар
<i>Шууд материалын зардал</i>	Тэжээлийн зардал бөгөөд мал аж ахуйн гаралтай бүх төрлийн тэжээл орно. Үүнд: байгалийн ба таримал өвс, тэжээлийн улаан буудай, арвай, овъёос, хивэг, хужир, дарш, хэвтрийн солом, вандуй, байгалийн шохой г.м.	Үр, хор, бордоо, шатахуун, дизель түлш гэсэн үндсэн түүхий эдийн зардлыг багтаана.
<i>Шууд хөдөлмөрийн зардал</i>	Малчин, төлчин, техникч, худгийн мэргэжилтэн гэх мэт ажилчдын үндсэн болон нэмэгдэл цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл	Тухайн ажилд шууд хамааралтай ажилчдын цалин хөлс орно. Жишээ нь: техникч, оператор, талбайн тогооч, механик, жолооч, агрономич
<i>Үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал</i>	<i>Шууд бус материалын зардал:</i> Хангамжийн материал, хөдөлмөр хамгаалал, эм тариа, аж ахуйн зардал, хүнс, цэвэрлэгээний материал, засварын зардал, цахилгаан дулааны зардал, сангийн зардал, шатахуун, тос масло, сэлбэгийн зардал, худаг, бусад үйл ажиллагаатай холбоотой зардал.	<i>Шууд бус материалын зардал:</i> бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шаардлагатай материал боловч хэрэглээ нь бага, завал гарах тодорхой норм тогтоож болдоггүй материалын зардал багтана. Жишээ нь: сэлбэг, тос масло, хүнс, хангамж, хөдөлмөр хамгаалал.
	<i>Шууд бус хөдөлмөрийн зардал:</i> Малзүйч, малын эмч, санитар, туслах ажилтан, гэрээт ажилтан, саальчин, засварчин, тогоочийн үндсэн болон нэмэгдэл цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл.	<i>Шууд бус хөдөлмөрийн зардал:</i> бүтээгдэхүүн үйлдвэрлэлд шууд оролцдоггүй боловч үйлдвэрлэл явуулах нөхцлийг бүрдүүлэх үүрэг бүхий ажилчдын цалин хөлсний зардал. Жишээ нь: туслах

		техникч, гагнуурчин, ачиж буулгах хэсгийн ажилчид, туслах болон үйлчилгээний ажилчид.
	Бусад шууд бус зардал: Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, даатгалын зардал, гадны байгууллагын хөлс, газрын төлбөр, малын татвар, нүүрсний зардал, авто машины түрээсийн зардал, өвчнөөр хорогдсон малын зардал (малын эмчийн актаар).	Бусад шууд бус зардал: түрээсийн зардал, дулаан, уур, усны зардал, хөрөнгийн даатгалын зардал, хөрөнгийн татварын зардал, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, засварын зардал, цахилгаан орно.

- б) Дээрх (а)-д дурдсан хөдөө аж ахуйн үйл ажиллагаанд хамаарах тэжээл, мал эмнэлгийн үйлчилгээ, тариалалт, хогийн ургамал зайлуулах, усалгаа, бордоо, ургац хураах, мал нядалгаа зэрэг үйлдвэрлэлийн зардлыг дэлгэрэнгүй орлогын тайланд чиг үүргээр (үйлдвэрлэл, захиргаа буюу хуваарилалтын зардал), эсвэл мөн чанараар (цалин хөлс, түүхий эд материал, элэгдлийн зардал) ангилан толилуулна.

4.4.3 Хөдөө аж ахуйн үйл ажиллагааны зардал

Үйл ажиллагааны зардлыг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалаар батлагдсан "Аж ахуйн нэгжийн Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ыг баримтална.

ТАВ. БИОЛОГИЙН ХӨРӨНГӨ БА ТҮҮНЭЭС ХҮЛЭЭН АВСАН ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ БОДИТ ҮНЭ ЦЭНИЙН ЗАГВАРААР ХЭМЖИХ НЬ

5.1. БИОЛОГИЙН ХӨРӨНГИЙН АНХДАГЧ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

- 5.1.1. Биологийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээс нь борлуулах зардлыг хассан дүнгээр хэмжиж бүртгэнэ.
- 5.1.2. Биологийн хөрөнгийг худалдан авч байгаа үед биологийн хөрөнгийн анхдагч олз эсвэл гарз үүснэ. Биологийн хөрөнгийн худалдан авч буй өртөг нь бодит үнэ цэнээс борлуулах зардлыг хассан дүнгээс их байвал борлуулах зардлаас алдагдал үүснэ. Тээврийн зардлын улмаас мөн анхдагч гарз үүсч болно /Хавсралт 1-ээс харна уу/.
- 5.1.3. Биологийн хөрөнгө худалдан авах үеийн журналын бичилт:
- | | | |
|--|------|------|
| Дт. Биологийн хөрөнгө /Бодит үнэ цэн - борлуулах зардал/ | xxxx | |
| Дт. Биологийн хөрөнгийн анхдагч гарз | | xxxx |
| Кт. Мөнгөн хөрөнгө | | xxxx |
- Дт. Биологийн хөрөнгө /БҮЦ-борлуулах зардал/
- | | | |
|-------------------------------------|------|------|
| | xxxx | |
| Кт. Мөнгөн хөрөнгө | | xxxx |
| Кт. Биологийн хөрөнгийн анхдагч олз | | xxxx |
- 5.1.4. Биологийн шинэ хөрөнгийг бий болгож тусад нь хүлээн зөвшөөрөх үед биологийн хөрөнгийн анхдагч олз үүснэ.
- 5.1.5. Биологийн шинэ хөрөнгө бий болох үеийн журналын бичилт:
- | | | |
|-------------------------------------|------|------|
| Дт. Биологийн хөрөнгө | xxxx | |
| Кт. Биологийн хөрөнгийн анхдагч олз | | xxxx |
- 5.1.6. Мал, амьтантай холбоотой биологийн шинэ хөрөнгийг хүлээн авах үед гол анхаарах асуудал нь үржлийн мал амьтны үнэ цэнийн бууралтын гарзыг анхны хүлээн зөвшөөрөлтийн бодит цэнээс суутгаж, уг дүнгээр биологийн хөрөнгийн анхдагч олзыг хүлээн зөвшөөрөх явдал юм. Жишээ нь, тугал, тоорой анх төрөх

үед тэдгээрийн бодит үнэ цэнээс үнээ, эсвэл мэгжний үнэ цэнийн бууралтыг суутган тооцож уг дүнг биологийн хөрөнгийн анхдагч олзоор хүлээн зөвшөөрнө. Биологийн шинэ хөрөнгө бий болох үеийн журналын бичилт: /Тугал төрөхөд/

Дт. Биологийн хөрөнгө /төл мал/	xxxx
Кт. Биологийн хөрөнгө /эх мал/	xxxx
Кт. Биологийн хөрөнгийн анхдагч олз	xxxx

5.2. ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АНХДАГЧ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

5.2.1 Биологийн хөрөнгөөс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг хүлээн авалтын үе дэх бодит үнэ цэнээс нь борлуулах зардлыг хассан дүнгээр хэмжиж, бүртгэнэ. (НББОУС 2 *Бараа Материал* болон холбогдох бусад СТОУС-ыг ашиглаж байгаа үед энэ хэмжилт нь тодорхой хөрөнгийн тухайн өдрөөрх өртөг байна).

5.2.2 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний анхдагч олз, гарз нь хүлээн авалтын үр дүнд үүссэн биологийн хөрөнгийн дансны үнийн бууралт ба тухайн хөрөнгөөс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн хоорондхи зөрүүг илэрхийлнэ. Хүлээн авсан бүтээгдэхүүнийг бараа материал руу шилжүүлнэ. Уг бараа материалыг цааш нь зах зээлд борлуулахад янз бүрийн бэлтгэл зардал гарч болно /Хавсралт 1-ээс харна уу/.

5.3. ТАЙЛАНТ ҮЕИЙН ЭЦСЭЭРХ ХЭМЖИЛТ

Тайлант үе бүрийн эцэст биологийн хөрөнгө ба хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээр хэмжиж, хүлээн зөвшөөрнө.

5.4. БОРЛУУЛАХ ӨРТГИЙГ ХАССАН БОДИТ ҮНЭ ЦЭН

5.4.1 Биологийн хөрөнгө болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бодит үнэ цэнийг ул үндэслэлтэй тооцоолсоны дараа түүний борлуулах өртгийг тодорхойлж хасах замаар Борлуулах өртгийг хассан бодит үнэ цэнийг тодорхойлно. Тайлант үе бүрийн эцэст биологийн хөрөнгө, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээр хэмжиж, хүлээн зөвшөөрнө.

5.4.2 Хөдөө аж ахуйн биржийн мэдээллийг ашиглан дараах шатлалын дагуу бодит үнэ цэнийг хэмжиж болно. Үүнд:

- а) Хөдөө аж ахуйн бирж дээрх тухайн хөрөнгийн дундаж үнэ /сар, улирлаар гаргаж буй дүн/;
- б) Тухайн хөрөнгийн хөдөө аж ахуйн бирж дээрх үнийг сар, улирлаар мэдэх боломжгүй үед бирж дээрх уг хөрөнгөд хамаарах хамгийн сүүлчийн ажил гүйлгээний үнэ;
- в) Хөдөө аж ахуйн бирж дээрх ижил төрлийн хөрөнгийн дундаж үнэ /зөрүүг тохируулсан/;
- г) Салбарын жишиг үнэ;
- д) Тухайн хөрөнгийг цаашид ашигласнаар ирээдүйд бий болохоор тооцсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэн.

5.5. БОДИТ ҮНЭ ЦЭНИЙН ӨӨРЧЛӨЛТ

5.5.1 Бодит үнэ цэн нь зах зээл дээрх үнийн ба биет өөрчлөлтөөс шалтгаалан өөрчлөгддөг. Биологийн хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн өөрчлөлт нь нэг тайлант үеэс дараагийн тайлант үеийн үнэ цэнийн хоорондох зөрүүг илэрхийлнэ. Уг үнэ цэн нь ургамлын ургалт, малын үржил, үнийн өсөлт зэргээс шалтгаалан нэмэгддэг боловч хөгшрөлт, муудалт, өвчлөл, үнийн уналтаас болж буурна.

5.5.2 Биологийн хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулах зардлыг хассан дүнгийн өсөлт, бууралтыг тухайн өөрчлөлт гарсан тайлант жилийн орлогын тайланд орлого, эсвэл зардлаар хүлээн зөвшөөрнө.

5.5.3 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг борлуулах үед биш харин түүний өсөлт, эсвэл нас дэвшилт болох үед энэ өөрчлөлтийг орлогоор хүлээн зөвшөөрнө.

5.5.4 Биологийн хөрөнгийг өсөлт эсвэл ургалтын аль ч үед борлуулж болно. Жишээ нь, хонь, ямааг аль ч үед, ямар ч насанд нь, тухайн үеийн зах зээлийн үнээр худалдаж болно. Гэхдээ хонь, ямааны үнэ нас ахих тусам өсөх хандлагатай байдаг. Биологийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг орлогын тайланд хүлээн зөвшөөрнө /Хавсралт 1-ээс харна уу/

5.5.5 Биологийн хөрөнгийн тайлант үеийн эхний ба эцсийн дансны үнийн өөрчлөлтийг тохируулах ёстой. Биологийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт нь дараах хүчин зүйлийн улмаас үүсдэг. Үүнд:

- а) Мал сүргийн хорогдол ба төрөлт - Биологийн хөрөнгө хувьсан өөрчлөгдөхийн хэрээр зарим хөрөнгө хорогдох эсвэл устах магадлалтай. Жишээ нь, таамаглаагүй цаг агаарын улмаас мал сүрэг хорогдох, ургац алдах.
- б) Өсөлт бойжилтоос үүссэн бодит үнэ цэнийн өөрчлөлт - Өсөлт бойжилтын улмаас бодит үнэ цэн өөрчлөгдөнө. Ноос ноолуур авах зорилгоор тэжээж байсан хонь хурганы бодит үнэ цэн ноосыг нь хяргасны дараа буурдаг.
- в) Үнийн өөрчлөлтөөс үүссэн бодит үнэ цэнийн өөрчлөлт
- г) Үнийн ба биет өөрчлөлтөөс үүссэн олз, гарзыг хэрхэн тохируулсанаа тусад нь толилуулах нь зүйтэй.

5.5.6 Биологийн хөрөнгөөс хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн хүлээн авсаны дараа бараа материал руу шилжүүлж, НББОУС 2 *Бараа Материал*-ын дагуу бүртгэнэ.

5.6. Аж ахуйн нэгж нь хөдөө аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой үйлдвэрлэлийн зардлыг биологийн хөрөнгөд капиталжуулах эсвэл зардлаар бүртгэхийн аль нэгийг сонгож, энэ хандлагаа тууштай баримтлах хэрэгтэй. Капиталжуулах зардлыг аж ахуйн нэгж нягтлан бодох бүртгэлийн бодлогодоо тусгаж өгөх нь зүйтэй. Орлогын тайланг чиг үүрэг (функц)-ээр нь толилуулдаг аж ахуйн нэгжүүд зардлаа капиталжуулна /Хавсралт 1-ээс харна уу/.

ЗУРГАА. БИОЛОГИЙН ХӨРӨНГӨ БА ТҮҮНЭЭС ХҮЛЭЭН АВСАН ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ӨРТГИЙН ЗАГВАРААР ХЭМЖИХ НЬ

6.1. БИОЛОГИЙН ХӨРӨНГИЙН АНХДАГЧ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

6.1.1. Биологийн хөрөнгийг анх удаа хүлээн зөвшөөрөхдөө дор дурдсан тохиолдолд өртгөөр нь хэмжиж, бүртгэнэ. Үүнд:

- а) Биологийн хөрөнгө бий болгохтой холбоотой анхдагч зардал гарснаас хойш маш бага хэмжээний биологийн өөрчлөлт бий болсон тохиолдолд өртөг нь бодит үнэ цэнтэй ойролцоо байх магадлалтай. Тухайн барааны үнэд биологийн өөрчлөлтийн үр нөлөө материаллаг биш тохиолдолд дээрхтэй адил гэж үзнэ.
- б) Бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжих боломжгүй байх тохиолдол. (Тухайн биологийн хөрөнгийн зах зээлийн мэдээллийг ашиглан түүний үнэ цэнийг тодорхойлох боломжгүй эсвэл бодит үнэ цэнийн тооцооллын аргуудыг найдвартай гэж үзэхээргүй бол.)

6.1.2. Биологийн хөрөнгийг худалдан авч байгаа үед худалдан авалтын өртгөөр нь хэмжиж, хүлээн зөвшөөрнө. Биологийн хөрөнгө худалдан авах үеийн журналын бичилт:

Дт. Биологийн хөрөнгө

xxxx

Кт. Мөнгөн хөрөнгө

xxxx

6.1.3. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хүлээн авалтын үе дэх бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжгүй тохиолдолд анх удаа хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь хэмжиж бүртгэнэ.

6.2. ДАРАА ҮЕИЙН ЗАРДАЛ

6.2.1 Энэхүү стандартын 3.3.2-р зүйлд тодорхойлсон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зардлыг биологийн хөрөнгө, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний өртөгт хуримтлуулан бүртгэнэ.

6.2.2 Өртгийн загварын дагуу дараа үеийн зардлыг биологийн хөрөнгө, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний дансанд хуримтлуулан, өртөг тооцох хандлагыг газар тариалангийн салбар ба фермерийн аж ахуйн хувьд авч үзлээ.

6.3. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН ӨРТӨГ ТООЦОЛТ

6.3.1 Шууд материал, шууд хөдөлмөр, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлыг “Дуусаагүй үйлдвэрлэл” дансанд хуримтлуулан бүртгэх бөгөөд уг дансыг үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний төрөл тус бүрээр нээнэ. Газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд уринш, боловсруулалт, тариалалт, ургамал хамгаалал, хураалт, хураалтын дараах зэрэг ажилбар тус бүрийн хувьд Шууд материал, Шууд хөдөлмөр, Үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал дансыг ашиглана.

6.3.2 Газар тариалангийн ажилбар дуусахад тухайн ажилбарт гарсан үйлдвэрлэлийн зардлыг “Дуусаагүй үйлдвэрлэл (улаан буудай, рапс гэх мэт) данс руу хаана. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртгийн хэмжээгээр бэлэн бүтээгдэхүүнийг орлогод авна. Газар тариалангийн бүх ажилбар дуусч, бэлэн бүтээгдэхүүнийг орлогод авах үедээ бэлэн бүтээгдэхүүний өртгийг бүтээгдэхүүний төрөл бүрээр тооцож, “Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртгийн тайлан”-г тус тусад нь бэлтгэнэ.

6.3.3 Тайлант үеийн зардлыг журналд дараах байдлаар тусгана:

а) Шууд материал зарцуулах үед:		
Дт. Шууд материал (Холбогдох ажилбар)	xxxx	
Кт. Түүхий эд матриал (Үр, хор, бордоо, шатахуун)		xxxx
б) Шууд бус материал зарцуулах үед:		
Дт. ҮНЗ (Холбогдох ажилбар)	xxxx	
Кт. Хангамжийн матеиал (Сэлбэг)		xxxx
в) Шууд хөдөлмөрт хамаарагдах ажилчдын цалингийн зардлыг бүртгэхдээ:		
Дт. Шууд хөдөлмөр (Холбогдох ажилбар)	xxxx	
Кт. Цалингийн тооцоо		xxxx
г) Шууд бус хөдөлмөрт хамаарагдах ажилчдын цалингийн зардлыг бүртгэхдээ:		
Дт. ҮНЗ (Холбогдох ажилбар)	xxxx	
Кт. Цалингийн тооцоо		xxxx
д) Үйлдвэрлэлд гарсан ашиглалтын зардал, даатгалын зардал, тээврийн зардал, түрээсийн зардлыг бүртгэхдээ:		
Дт. ҮНЗ (Холбогдох ажилбар)	xxxx	
Кт. Мөнгөн хөрөнгө, Өглөгийн данс		xxxx
е) Үйлдвэрлэлд ашигласан машин тоног төхөөрөмжийн элэгдлийн хэмжээгээр		
Дт. ҮНЗ (Холбогдох ажилбар)	xxxx	
Кт. Хуримтлагдсан элэгдэл		xxxx
ё) Засварын зардлын хувьд		
Дт. ҮНЗ (Холбогдох ажилбар)	xxxx	
Кт. Мөнгөн хөрөнгө, сэлбэг		xxxx

- ж) Газар тариалангийн бүх ажилбар дуусч, өртөг тооцохын тулд бүтээгдэхүүний ажилбар тус бүрээр гарсан “Шууд материал”, “Шууд хөдөлмөр”, “Үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал”-ыг “Дуусаагүй үйлдвэрлэл-Бүтээгдэхүүний өртөг” данс руу хаана. Жишээлбэл, буудайн хувьд дараах бичилт байна:

Дт. Дуусаагүй үйлдвэрлэл- буудай	xxxx	
Кт. Шууд материал		xxxx
Кт. Шууд хөдөлмөр		xxxx
Кт. ҮНЗ		xxxx

- з) Бэлэн бүтээгдэхүүнийг орлогод авахдаа:

Дт. Бэлэн бүтээгдэхүүн – Буудай	xxxx	
Кт. Дуусаагүй үйлдвэрлэл - Буудай		xxxx

6.4. МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН ӨРТӨГ ТООЦОЛТ

- 6.4.1 Тайлант хугацааны үйлдвэрлэлийн зардлыг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн ба биологийн хөрөнгө, түүний нас дэвшилт, төлд нь тодорхой сууриар хуваарилан шингээнэ. Мал аж ахуйн салбарын онцлогоос шалтгаалан өртгийн дансыг жилд нэг удаа үүлдэр угсаа эсвэл малын төрлөөр тус тусад нь хаана. Тайлант хугацааны өртөгт шингэх нийт зардлыг:

а) өөрийн өртөг ба төлд шингээх /Биологийн хөрөнгө/

б) сүү, ноос ноолуур гэх мэт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд шингээх гэж зааглана.

- 6.4.2 Нийт үйлдвэрлэлийн зардлыг биологийн хөрөнгө ба хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд хуваарилах суурийг аж ахуйн нэгж нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтээ тодорхойлсон байна. Жишээ нь: тайлант жилийн төсөвлөсөн орлого, төл малын борлуулалтын орлого, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтын орлогын хувийн жингээр хуваарилж болно.

- 6.4.3 Биологийн хөрөнгийн өртөгт шингэх үйлдвэрлэлийн зардлыг өөрийн өртөг ба төл малд хуваарилна. Жишээ нь: тодорхойлсон суурьт үндэслэн нийт тэжээлийн зардалд малын нас бүрийн эзэлж байгаа хувиар биологийн хөрөнгөд шингээх зардлын дүнг тодорхойлж, түүнийг төл мал болон нас дэвшсэн малд хуваарилна.

- 6.4.4 Мал аж ахуйтай холбогдон гарах бүх зардлыг /сүүтэй холбогдон гарах зардал, хөөвөр бэлтгэхтэй холбогдон гарах зардал хамаарахгүй/ төрөл тус бүрийн өртгийн дансанд бүртгэнэ.

Дт. Мал аж ахуйн өртгийн данс	xxxx	
Кт. Мөнгөн хөрөнгө, бараа материал		xxxx
	xxxx	

Дт. Өөрийн өртөг ба төлд шингэх данс		
Кт. Өртгийн данс		xxxx

- 6.4.5 Мал аж ахуйн өртгийн дансанд малын тэжээлийн зардал, малчны цалин, шатахуун тээврийн зардал гэх мэт зардлыг багтаана. Өөрийн өртөг ба төлд шингэх дансыг хаахдаа:

Дт. Төлд шингээх данс	xxxx	
Дт. Нас дэвшилтэнд шингээх данс	xxxx	
Кт. Өөрийн өртөг ба төлд шингээх данс		xxxx

- 6.4.6 Төлд шингээх дансанд хуримтлагдсан зардлыг мал амьтадын дансанд хаахдаа:

Дт. Мал амьтдын данс /тугал/	xxxx	
Кт. Төлд шингэх данс		xxxx

- 6.4.7 Нас дэвшилтэнд шингээх дансыг мал амьтдын дансанд хаахдаа:

Дт. Мал амьтдын данс /Үнээ/	xxxx	
Дт. Мал амьтдын данс /Бяруу/	xxxx	

	Кт. Нас дэвшилтэнд шингээх данс	xxxx	
6.4.8	Сүүтэй холбогдон гарах Саальчны цалин, сүү тээвэрлэхтэй холбоотой зардал, бусад холбогдох зардлыг Мал аж ахуйн зардлаар бүртгэнэ.	.	
	Дт. Мал аж ахуйн зардал	xxxx	
	Кт. Мөнгө, Бараа материал, Цалин		xxxx
6.4.9	Мал аж ахуйн зардлын дансыг хаахдаа:		
	Дт. ОЗНД	xxxx	
	Кт. Мал аж ахуйн зардал		xxxx
6.4.10	Холбогдон гарах зардал (ямаа самнах, хонь хяргах)-ыг үйл ажиллагааны зардлаар бүртгэнэ.		
	Дт. Мал аж ахуйн зардал	xxxx	
	Кт. Мөнгө, Бараа материал, Цалин		xxxx
6.4.11	Харин ноос ноолуурын өртгийг мал аж ахуйн өртгийн дансанд хуваарилна:		
	Дт. Ноос ноолуурын өртөг	xxxx	
	Кт. Мал аж ахуйн өртгийн данс		xxxx

ДОЛОО. ХӨДӨӨ АЖ АХУЙН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ӨНЦЛОГ АСУУДАЛ

7.1 ЭХ УРГАМАЛЫН ХЭМЖИЛТ

- 7.1.1. НББОУС 16 Үндсэн хөрөнгө-ийн хамрах хүрээнд багтах эх ургамлыг боловсорч гүйцэх хүртэл нь хуримтлагдсан өртгөөр хэмждэг. Боловсорч дууссан хугацаанаас хойшхи дараагийн үеүдэд гарсан зардал нь уг хөрөнгийн ирээдүйн эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэхгүй байвал зардлаар хүлээн зөвшөөрнө.
- 7.1.2. НББОУС 16 Үндсэн хөрөнгө-ийн дагуу өртгийн загвар, эсвэл дахин үнэлгээний загварын аль нэгийг сонгон тухайн хөрөнгийн ангилалд бүхэлд нь ашиглах бөгөөд аль ч загварын хувьд эх ургамлыг ашиглалтын хугацаанд элэгдүүлнэ.
- 7.1.3. Боловсорч гүйцээгүй эх ургамлыг үйлдвэрлэлийн процесст байгаа хөрөнгө мэтээр бүртгэх ба уг хөрөнгийг удирдлагын төлөвлөсөний дагуу ашиглахад шаардлагатай байршил ба нөхцөлд хүргэх хүртэл өртгийг хуримтлуулан бүртгэнэ (өөрөөр хэлбэл боловсорч гүйцэх хүртэл).
- 7.1.4. Аж ахуйн нэгж эх ургамлыг боловсорч гүйцсэн үеэх эхлэн элэгдэл тооцох бөгөөд элэгдлийн аргыг сонгохдоо эх ургамлаас ирээдүйд хүртэхээр таамаглаж буй эдийн засгийн өгөөжийн төлөв байдлыг харгалзан үзнэ. Эх ургамлын үнэ цэнийн бууралтыг НББОУС 36 *Үнэ Цэнийн Бууралт*-ын дагуу хэмжиж бүртгэнэ.

7.2. ЗАСГИЙН ГАЗРЫН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ

- 7.2.1. Борлуулалтын зардлыг хасаж тооцсон бодит үнэ цэн бүхий биологийн хөрөнгөтэй холбоотой тодорхой нөхцөл заагаагүй засгийн газрын буцалтгүй тусламжийг зөвхөн тухайн тусламжийг хүлээн авч болох нөхцөл бүрдсэн үед ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.
- 7.2.2. Хэрэв тодорхой нөхцөл заасан буцалтгүй тусламжийг хүлээн авч байгаа бол тухайн нөхцлийг хангасан үед уг буцалтгүй тусламжийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.
- 7.2.3. Хөдөө аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой бөгөөд биологийн хөрөнгөөс бусад хэлбэрээр хүлээн авч байгаа засгийн газрын буцалтгүй тусламжийг зөвхөн хүлээн авах нөхцөл бүрдсэн, тодорхой нөхцлийг хангасан үед л бодит үнэ цэнээр нь ашиг алдагдалд хүлээн зөвшөөрнө.

НАЙМ. ТАЙЛБАР, ЖИШЭЭ

Энэхүү жилиээ нь уг стандартын хамт хэрэглэгдэх баримт бичиг боловч түүний үндсэн бүрэлдэхүүн хэсэг болохгүй.

Бодит үнэ цэнийн загвар

1. Фермерийн аж ахуй эрхэлдэг “Г” компани тусгай үүлдрийн үхрийг ирээдүйд борлуулах зорилгоор нас гүйцэх хүртэл нь өсгөж үржүүлдэг.

а) Нядалгаа хийдэггүй үйл ажиллагаанд хамаарах дараах мэдээлэл байна. Үүнд:

- Компани 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдөр байгуулагдсан. Байгуулагдах үедээ 100 төл мал (тугал), 50 нас гүйцсэн үхэр худалдаж авсан.
- Нэг жил болсон төл малыг нас гүйцсэн гэж үздэг.
- Тайлант жилийн үйл ажиллагаанд хийсэн шинжилгээнээс харвал жил бүрийн 12 дугаар сарын 31-ний дотор бүх шилжилт хөдөлгөөн (нас дэвшил), ажил гүйлгээ гардаг.
- Тээврийн зардлыг нэг мал (хувьсах зардал)-д ногдох байдлаар тооцсон болно. Практик дээр, малын тоо хэмжээний хувьд энэ зардлыг тогтмол зардал гэж үзнэ.

Нас гүйцсэн болон төл мал борлуулах зардал, бодит үнэ цэнийн мэдээлэл:

	2012 он	2013 он	2014 он	2015 он
Нэгжийн бодит үнэ цэн (төл мал)	100.00	105.00	110.00	116.00
Нэгжийн бодит үнэ цэн (нас гүйцсэн)	150.00	153.00	156.00	159.00
Борлуулах зардал:				
